

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

И.БААТАР*

Монголын заншлаар газар тариаланг хөдөө аж ахуй гэж нэрлэдэг. Монголын хөдөө аж ахуй нь мал аж ахуй, газар тариаланг хамаардаг. Монголын мал аж ахуй нэн эртний түүхтэй бөгөөд ардын хувьсгалаас өмнө газар тариалан бараг үгүй байсан, хувьсгалаас хойш Монголын Засгийн газар ХАА-г хөгжүүлэхэд маш их анхаарч 1927 онд анхны үр тарианы аж ахуй болох Жаргалантын улсын САА байгуулж 30-аад оны үеийн хамтралжуулалт (хоршоололт) 60-аад оноос хойшхи аж үйлдвэрлэлжүүлэлт, 80-аад оны эдийн засгийн шинэтгэл ба 90-ээд оны үеийн улс төрийн хувиралт өөрчлөлтийг өнгөрөөж Монголын ХАА-д асар их өөрчлөлт гарлаа.

Нэг. Гурван их үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт

1. Монголын ХАА-д ажиллагчдын хувийн жин улс ардын аж ахуйн бүх салбарт ажиллагчдын бүтцэд илэрхий буурах хандлагатай байна. 1960 оноос 1990 он хүртэл 10 жил тутамд 9%, 12,5%, 6,3%-иар тус тус буурав. 1991 оноос хойш Монголын ХАА-д ажиллагчдын хувийн жин өсөх болж 1996 онд 45,2% - д хүрч 1990 оныхоос 12,2%-иар өссөн боловч 1960 оныхоос доогуур байв. Монголын ХАА-д ажиллагчдын хувийн жин буурч байгаа нь ХАА-н үйлдвэрлэл хөгжиж, хөдөлмөрийн бүтээмж дээшилсэний үр дүн юм.

2. Монголын ХАА-н үйлдвэрлэлийн өртөг нийгмийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх хувийн жин (1985 оноос хойш GDP) илэрхий буурах хандлагатай байна.

1921 онд Ардын хувьсгал ялах үед тус орны эдийн засаг үндсэндээ хүй нэгдлийн хоцрогдсон бүдүүлэг мал аж ахуйн бүтэц бүхий дан ганц салбартай байв. Улсын хүн амын 90% нь малчид, үндэсний орлогын 90-ээс дээш хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс орж байлаа.

1960 оноос хойш анхдагч үйлдвэрлэлийн өртөг зогсолтгүй буурч 1960 онд өнгөрсөн оныхоос 19,7%-иар буурч мөн онд Монголын нийгмийн нийт бүтээгдэхүүнд эзлэх анхдагч хоёрдагч гуравдагч үйлдвэрлэлийн өртөг 19,7:34,9:45,4% болж анхдагч үйлдвэрлэлийн өртөгийн хувийн жин гуравдугаарт ортол буурав. Энэ

* И.Баатар - ӨМӨЗО-ны Их сургуулийн багш, профессор

үед анхдагч үйлдвэрлэлийн өртөг буурч олон төрлийн аж ахуйн шинэ салбарын аж үйлдвэр барилга, орчин үеийн зам тээвэр, харилцаа холбоо бий болж түргэн хурдацтай хөгжлөө.

1992 онд Монголын анхдагч үйлдвэрлэлийн өртөг дээшилж GDP нийт өртөгт эзлэх хувийн жин 30,2% 1994 онд хамгийн өндөр 36,9%-д хүрэв. Мөн GDP-гийн нийт өртөгт эзлэх хувийн жин эхний байранд гарч анхдагч хоёрдагч гуравдагч үйлдвэрлэлийн харьцаа 36,9:32,9:30,4% болов. Гэвч энэ нь 1940 оны төвшинтэй харьцуулахад мөн л доогуур хэвээр байв. 1990 онд Монголын улс төрийн байдал өөрчлөгдсөний дараа зах зээлийн эдийн засгийн шилжилт эхлэн Монголын эдийн засаг ноцтой доройтсоны дотор аж үйлдвэрлэл илт унаж ХАА-н үйлдвэрлэл харьцангуй тогтвортой байв.

3. Монголын үйлдвэрлэлийн чанартай тогтвортой хөрөнгийн бүтцэд ХАА-н үндсэн хөрөнгийн эзлэх хувийн жин мэдэгдэхүйц буурах хандлага гарав. 1940-1990 оны байдлыг авч үзвэл ХАА-н үндсэн хөрөнгийн хувийн жин 1990 онд 1940 оныхоос 66,2%-иар буурч үйлдвэрлэлийн чанартай тогтвортой хөрөнгийн бүтцэд анхдагч хоёрдагч гуравдагч үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 13,7:35:13,9% болж ХАА-н үйлдвэрлэл 3-р байранд орох болов.

Хоёр. ХАА-н өмчийн бүтцийн өөрчлөлт

Монгол улс 30-иад оноос эхлэж үйлдвэр хоршоолол байгуулав. 1959 оны эцсээр Монголын ХАА-н хоршооллын хөдөлгөөн амжилттай дуусав. Монголын ХАА-н өмчийн бүтцэд чанарын өөрчлөлт гарч мал аж ахуйн өмчийн бүхий л салбарын бүтцэд хамтын өмч давамгайлаж хувийн өмчийн мал аж ахуй хэрэг дээрээ устсан боловч амины өмчийн мал аж ахуй хадгалагдан үлдсэн юм. 1985 оны эцсээр монголын мал аж ахуй өмчийн бүтцэд бүх ард түмний өмч 7,7% хамтын өмч 70,1% амины өмч 22% эзлэж байв. Газар тариалангийн салбар нь улсын САА ба ХАА нэгдлийн хэлбэрээр бүх ард түмний хамтын өмчийн нэгдмэл байр суурьтай байв.

1990 оны 3-р сард монголын бүх төрлийн өмчийн хэлбэр улсын өмч хөрөнгө бүгд хувийн болов. 1991 оны 5-р сарын 13-ны өдөр Монголын Засгийн газраас (Монгол улсын хувийн өмчийн хууль) гаргав. 1994 онд хөдөөд хувийн өмчийн малын тоо толгой бүх улсын малын тоо толгойн 70,4% улсын болон хамтын өмч 29,6% эзлэж байв.

1996 он гэхэд хувийн өмчийн малын тоо толгойн эзлэх хувийн жин 93,4% болов. Хувийн өмчийн аж ахуй маш хурдацтай өсөж ХАА-н өмчийн олон нийтийн өмчийн шинж чанар түргэн хурдацтай өөрчлөгдөв.

Гурав. ХАА-н дотоод бүтцийн өөрчлөлт

1. ХАА-н үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт.

Монголын ХАА-д мал аж ахуй, газар тариалан ой мод, ан агнуур зэрэг салбар хамардаг. Мал аж ахуй бол Монголын уламжлалт салбар бөгөөд 1927 онд Монголд анхны үр тарианы Жаргалантын САА байгуулагдсанаар газар тариалан хөгжиж эхэлсэн боловч 1940-д он хүртэл газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжилт маш удаан байв.

1959 онд Засгийн газраас их хэмжээгээр атар хагалаж газар тариаланг хөгжүүлэх, үр тариагаар өөрийгөө хангах уриа дэвшүүлснээр газар тариалан харьцангуй хурдан ХАА-н нийт өртөгт эзлэх үйлдвэрлэлийн өртгийг нь хувийн жин түргэн өсөж 1960 онд 15,8%, 1980 онд 18,3%, 1990 онд 30,3% хүрч энэ үед Монголын газар тариалангийн өртөг 11,9% хүртэл буурав.

2. МАА-н дотоод бүтцийн өөрчлөлт.

Монгол улс өнө эртний малын аж ахуйн түүхтэй тул “уламжлалт бэлчээрийн мал аж ахуй” гэж хүмүүс нэрлээд дадчихсан байдаг. Эртнээс таван хошуу мал сүрэг, тухайлбал үхэр, адуу, тэмээ, хонь, ямаа маллаж ирсэн юм. Монголчууд “таван эрдэнэ” гэж мал сүргээ дээдэлдэг. 1930-1997 оны хооронд Монголын малын тоо толгой өсөж, буурсаар 1997 он гэхэд 31 сая 260 мянган тоо толгойд хүрч 1996 оныхоос 6,7%-иар өсөв. Энэ бол түүхэнд мал хамгийн их өссөн жил байлаа. 1945 онд Монголын мал 20 сая 10 мянга хүртэл буурсан нь түүхэн дэхь хамгийн цөөн малтай жил байв. Гэвч Монголын малын тоо толгой өсөх хандлагаар явж байв.

Хэдийгээр Монголын малын тоо толгой өсөж буурахыг дагалдан таван хошуу малын бүтцэд бас өөрчлөлт гарлаа.

Тэмээ. Малын нийт тоо толгойн дотор тэмээний тоогоор 5-рт ордог. 1997 онд 350 мянган тэмээтэй болсон нь 1996 оныхоос 0,8%-иар буурчээ. 60-аад онд тэмээний тоо 859100-д хүрч нийт малын дотор эзлэх хувийн жин 3,7% болж тэмээ хамгийн их өсөж байсан жилүүд байв.

Үүнээс хойш тэмээний тоо толгой нийт малын дунд эзлэх хувь нь аажмаар буурав.

Адуу: адууны тоо нийт малын дотор 4-рт ордог. 1997 онд адууны тоо 2 сая 890 мянган толгойд хүрч 1990 оныхоос 4,4%-иар өсөв. Нийт малын өсөлт доошилсон боловч тухайн жилд адууны тоо нийт малын 9,2%-ыг эзлэж байв. 60,70-аад оны үед нийт малын дотор эзлэх адууны хувийн жин 10,9% ба 10,3% хүрч байсан нь түүхийн хамгийн өндөр үзүүлэлт байв. 80,90-ээд оны дунд үед тогтворгүй болсоноо хэдэн жилийн дотор, өсөлт нь эргэн дээшлэв.

Үхэр. Нийт малын дотор 3-рт ордог. 1997 онд үхэрийн тоо

3 сая 610 мянга болж 1996 оныхоос 3,9%-иар өссөн ч нийт тоо толгойн өсөлт буурсан юм.

Ямаа. Ямаа бол Монголын малын нийт малын дотор 2-рт ордог. 1997 онд 10 сая 256 700 ямаатай болж 1996 оныхоос 12,3%-иар өсөж нийт тоо толгойн өсөлт нь дээшлэв. Тухайн жилд ямааны тоо толгойн нийт малын 32,8%-ыг эзлэж мөн оны ямааны тоо толгой хувийн жин түүхэнд хамгийн өндөр жил байв. Таван хошуу малын дотор ямаа хамгийн хурдан хамгийн их өсдөг нь юм.

Хонь. Монголын нийт малын тоо толгой дотор хонь 1-рт ордог. 1997 онд хонины тоо толгой 14 сая 140 мянгад хүрч 1996 оныхоос 4,3%-иар өссөн ч нийт өсөлтийн хувь нь буурсан юм. Мөн онд хонины тоо бүх малын 45,2%-ыг эзлэж байсан ба хонины тоо хамгийн их өсөж байсан жил нь 1940 он бөгөөд 15 сая 380 мянган хоньтой байв.

Нийт малын дотор хонины эзлэх хувийн жин хамгийн өндөр байсан нь 1980 он бөгөөд 59,9%-д хүрч байв. Хонины тоо толгой нийт малын дотор эзлэх хувь нь буурах хандлагатай байна.

3.Мал аж ахуйн бүтээгдэхүүний бүтцийн өөрчлөлт. Мал аж ахуйн бүтээгдэхүүний бүтцэд махны төрөл үхэр, хонь, гахайн мах болон хонины ноос, үнээний сүү, шар тос, /масло/ тахианы өндөг ордог.

Мах. 1960 оноос хойшхи байдлыг харвал махны үйлдвэрлэлийн хэмжээ төдийлөн тогтвортой биш. Заримдаа өсөж заримдаа буурч байсан боловч үндсэндээ өсөх хандлагатай байлаа. 1991 онд махны үйлдвэрлэлийн хэмжээ 281200 тонн хүрсэн нь түүхийн хамгийн өндөр үзүүлэлт юм. 1992 оноос хойш буурсаар 51200 тонн болсон ч 1960 онд 184500 тн байснаас өндөр байгаа юм.

Махан бүтээгдэхүүний бүтцэд 1-рт хонины мах 2-рт үхэрийн мах 3-рт гахайн мах ордог. Түүний дотор хонь гахайн мах нь махны төрлийн бүтцэд эзлэх хувийн жин нь буурах хандлагатай бөгөөд үхрийн мах өсөх хандлагатай байна. 1996 онд махан бүтээгдэхүүний бүтцэд хонь ба үхрийн махны эзлэх хувийн жин 46,2 ба 34,5% болж 60 оныхоос хонины мах 5,9%-иар буурч үхрийн мах 3,4%-иар өсөв. Гахайн махны хувийн жин маш бага байна.

Хонины ноос. Хонины ноос үйлдвэрлэл махны үйлдвэрлэлийн нэгэн адил өсөх хандлагатай бөгөөд 1991 онд 21500 тн-д хүрч, түүхийн хамгийн дээд түвшин байв. 1992 оноос хойш буурч байгаа боловч 1960 оны 15200 тн байсан түвшингөөс өндөр байгаа юмаа.

Үнээний сүү. Сүү үйлдвэрлэлийн хэмжээ төдий л тогтвортой биш боловч үндсэндээ, мөн л өсөх хандлагатай байна. 1996 онд

сүүний үйлдвэрлэл 365 мянга 700 тн болж 1980 оныхоос 62% 1970 оныхоос 65,8%-иар өсөв.

Шар тос. Шар тосны үйлдвэрлэлийн нийт хэмжээ буурч байгаа бөгөөд 1960 онд 4800 тн шар тос үйлдвэрлэж байсан нь түүхийн хамгийн их үзүүлэлт байв. 1994 оныг 1960 оныхтой харьцуулбал шар тосны үйлдвэрлэл 95,8%-иар буурлаа.

Тахианы өндөг. Өндөг үйлдвэрлэл маш тогтворгүй бөгөөд 1996 онд 4,9 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь Монголын түүхэнд хамгийн их өндөг авч байсан 38 сая ширхэгтэй хөрьцуулбал 87,1%-иар буурч бууралтын хэмжээ харьцангуй их байгаа ч 1960 оны төвшингөөс өндөр байгаа юмаа.

4. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт

Тариалангийн үйлдвэрлэлд гол нь үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал багтана. 1996 онд тариалангийн талбай, 347800 км² болж 1960 онд 266 км² байсныг эс тооцвол жил бүр буурсаар байв. 1989 онд тариалангийн талбай хамгийн их буюу 837,900 км²-д хүрч 1996 оныхоос 1,4 дахин илүү байна. Тариалангийн талбайн бүтцэд үр тарианы талбайн эзлэх хувийн жингээр үр тариа 1-рт, төмс 2-рт, тэжээлийн ургамал 3-рт, хүнсний ногооных 4-рт ордог. Түүний дотор үр тарианы талбай харьцангуй их бөгөөд 1996 онд тариалангийн нийт талбайн 96,6%-ыг бусад ургамалын 5%-д хүрэхгүй байна.

Хүнсний ногоо тариалах талбай өсөж бусад ургамалынх харилцан адилгүй хэмжээгээр буурч байна.

Хөдөө аж ахуйн тарьмал ургамалын үйлдвэрлэлийн хэмжээ буурах хандлагатай бөгөөд бууралтын хэмжээ нь маш их байна. 1996 онд таримал ургамалын үйлдвэрлэл 220100 тн болж түүхийн хамгийн өндөр ургацтай 1985 оны 886200 тн-той харьцуулвал 75,2%-иар буурч улмаар 1960 оны төвшингөөс ч бага байна.

Хөдөө аж ахуйн таримал ургамалын үйлдвэрлэлд улаан буудайн үйлдвэрлэл нилээд давуу байр эзлэнэ. 1996 онд улаан буудайн ургацын хэмжээ 215300 тн, төмс 46000 тн, хүнсний ногоо 238000 тн, тэжээлийн ургамал 188000 тн байлаа.

Дээр дурьдсаныг нэгтгэн хэлбэл:

1. 1990 он бол Монголын ХАА-н хөгжилд өөрчлөлт гарахын заагийн шугамд болж 1970-аад оноос хойш Монголын анхдагч үйлдвэрлэл илэрхий буурах хандлагатай болов. Нөгөө талаар Монголын мал аж ахуй нь хөдөө аж ахуйд тэргүүлэгч байр суурьтай болов.

2. 1990 оноос хойш Монголын ХАА-н үйлдвэрлэл маш хүнд

цохилтонд өртөж, өмч хувьчлал юуны өмнө газар тариалан мал аж ахуйн районд хэрэгжиж ХАА-н орчин үеийн байгууламж эвдэрч, орчин үеийн техник тоног тохөөрөмжийн хэмжээ харилцан адилгүй хэмжээгээр буурлаа.

3. 1990 оны эцэс гэхэд үр тариаг бүрэн хэмжээгээр импортонд түшиглэн өөрийгөө хангаж байсан боловч Монголын газар тариалангийн бүтээгдэхүүний төрөл зүйл хомсдож үйлдвэрлэл нь буурч тогтворгүйтэн, маш ихээр хэврэг сул болов.

Хятад хэлнээс орчуулсан Л.БЭГЗЖАВ